



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2016 оны 01 сарын 12 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

Тушаалд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Төрийн өмчийн хорооны “Ногдол ашгийн хувь хэмжээг тогтоох тухай” 2014 оны 232 дугаар тогтоол, “Ногдол ашгийн хувь хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 2015 оны 572 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Жагсаалт шинэчлэн батлах тухай” Зам, тээврийн сайдын 2015 оны 263 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Иргэний нисэхийн ерөнхий газрын 2014 оны үйл ажиллагааны цэвэр ашгийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт”-ын 2.13-ын “Тавилга, эд хогшил, техник хэрэгсэл” гэснийг “Чингис хаан ОУНБ-ын транзит заалны зарим хэсгийн засвар, тохижилтийн ажил” гэж өөрчилсүгэй.

2. Мөн жагсаалтын 1.8-д заасан “Чойбалсан болон Ховд нисэх буудлын гэрэл суултын системийн кабель /27000 метр/” ажлын хэмнэлт 28,9 сая төгрөг, 2.5-ын “Тэсрэх бодис илрүүлэгч төхөөрөмж” ажлын хэмнэлт 43,0 сая төгрөг, 2.6-ын “Аюулгүйн үзлэгийн иж бүрэн тоног төхөөрөмж” ажлын хэмнэлт 117,0 сая төгрөг, “Жагсаалт шинэчлэн батлах тухай” Зам, тээврийн сайдын 2015 оны 127 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Иргэний нисэхийн ерөнхий газрын 2013 оны үйл ажиллагааны цэвэр ашгийн зарцуулагдаагүй үлдэгдлээс санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтын 1-ийн “Санхүүгийн цогц иж бүрэн программ” ажлын хэмнэлт 39,3 сая төгрөг, нийт 228,2 сая төгрөгийн хөрөнгөөр “Чингис Хаан ОУНБ-ын ирэх, явах заалны засвар, тохижилтын ажил”-ыг санхүүжүүлэн хэрэгжүүлэхийг Иргэний нисэхийн ерөнхий газар /Г.Нямдаваа/-т зөвшөөрсүгэй.

3. Тушаалд өөрчлөлт оруулсантай холбогдуулан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох хууль, журам, шийдвэрийн дагуу шуурхай зохион байгуулж, бүрэн хэрэгжүүлэхийг Иргэний нисэхийн ерөнхий газар /Г.Нямдаваа/-т даалгасгай.

4. Энэхүү тушаалаар батлагдсан төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Б.Жаргал/-т үүрэг болгосугай.

САЙД



М.ЗОРИГТ